



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.04.18 № 2/258  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн Г  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Монгол ардын намын хорооноос ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Монгол ардын намын хорооны Баян-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн

005020559

тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод тус тус нийцсэн байна.

Баян-Овоо сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /6 хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Сонгуулийн хороонд Хавсралт ...<sup>6</sup> хуудаастай.

АУДИТЫН  
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА



БАТЛАВ  
БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
ДЭД ДАРГА *[Signature]* Г.ГАНЦООЖ

БАЯН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ 2020-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2023 оны 04 дүгээр сарын 10

Хөхбүрд

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн:**

- 1.1.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, Иргэд ААН-ийг “Орон нутгийн хөгжлийн сан болон бусад зээл хөтөлбөрт хамруулан зээл олгоход дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.2 Өрхийн оёдлын цех дэмжих хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Хөдөө орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.5 Иргэдийн туршлага ур чадварт түшиглэн хувиар хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээлд хамруулна.

**1.2 Хуримтлалын нэгдсэн сан ба орон сууцтай өрх**

- 1.2.1 Суманд орон сууцыг барьж буй аж ахуйн нэгж, иргэдийг дэмжиж ажиллана.
- 1.2.2 Нийгмийн даатгалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, “Хуримтлалын нэгдсэн сан” байгуулан иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болох тогтолцоог бий болгоно.
- 1.2.3 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж, орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэн бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.


**1.3 Эрүүл иргэн:**

- 1.3.1 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж эмч, мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоо бүрдүүлнэ.

*[Signature]*  
000001



- 1.3.2 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.3 “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөр үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, “Эрүүл ирээдүй” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Эмэгтэйчүүдийн товлотт дархлаажуулалтыг аймгийн хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүү, хөхний хорт хавдраас сэргийлэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, ур чадварыг тасралтгүй дэмжиж, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулан “Цогц чадамжтай эмч” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.7 Эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулан, нийгэмд эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн “ Эрүүл мэндийн салбарын эелдэг ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.8 Бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэгийн халдварыг улс, аймгийн дунджаас бууруулан, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.3.9 Охидын жирэмслэлт, үр хөндөлт төрөлтийг бууруулан, өсвөр насны охидын нөхөн үржихүйн эрүүл мэндэд учрах эрсдэлээс сэргийлж, зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.3.10 Ахмад настны эрүүл мэндийг дэмжиж, эмчилгээний дараах сувилахуй болон нөхөн сэргээх төрөлжсөн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.
- 1.3.11 Эрүүл мэндийн төвийн барилга шинээр барина.



000002




#### **1.4 Чанартай боловсрол:**

- 1.4.1 Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.2 Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах дохионы хэлний багш бэлтгэхэд дэмжин ажиллана.
- 1.4.3 Өдөр өнжүүлэх бүлгийн ажиллах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.4 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4.5 Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэхэд анхаарч фитнес заалны үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 1.4.6 Хувь хүн гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулна.
- 1.4.7 Сурагчдын сурлагын амжилт, чанар стандарт хангалтыг сайжруулах бодлогын дэмжиж "Сайн багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### **1.5 Тогтвортой- Амар амгалан гэр бүл**

- 1.5.1 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.5.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамж үйлчилгээг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.5.3 Хувь хүн гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.4 Хөдөлмөр эрхлэлт зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.
- 1.5.5 Гадаадад хөдөлмөр эрхэлж мэргэжил эзэмшиж буй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, тэдний орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.6 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж Сумын төвийг бүрэн камертай болгоно.

  
000003




- 1.5.7 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж хяналтыг сайжруулна.
- 1.5.8 Сумд Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх газруудын тоог нэмэгдүүлнэ.
- 1.5.9 Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төв, цэцэрлэгт хүрээлэнг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.10 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөнгөлөлт эдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.5.11 Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.12 Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлэх журам боловсруулж, хэрэгжүүлнэ. Түүх угсаатны зүйн музейн түүх дурсгалын үзмэрүүдийг олон нийтэд таниулах орчин бүрдүүлнэ.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 2.1 Бие даан хөгжих эдийн засгийн нөөц бололцоог судалж, хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 2.2 Арьс шир боловсруулах цехийн үйл ажиллагааг тогтворжуулна.
- 2.3 Мод модон бүтээгдэхүүнийг үйлдвэр, оёдлын цехийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжинэ.
- 2.4 Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа, аж ахуй нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулж үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.
- 2.5 Сумын хөгжил" хөтөлбөр хэрэгжүүлж, сумын төвийн айл өрхийг инженерийн шугам сүлжээгээр холбож, гудамж хорооллыг зам гэрэлтүүлэгтэй болгоно.
- 2.6 Сумын төвд хатуу хучилттай 2 км зам тавина
- 2.7 Нарийн гол Хоолтын гарамд төмөр бетон гүүр барина

## **ГУРАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

- 3.1 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн "Нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр, төрийн албан хаагчийн "Сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлж

 ПЛЛНННН



“Орон сууц хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна.

3.2 Хариуцлагатай төрийн албан хаагч, хариуцлагатай засаглал хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.3 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хянах нөхцөлийг сайжруулах.

3.4 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайтай тэмцэхэд иргэн төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих замаар мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5 Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлж зохих нөөцийг бүрдүүлнэ.

3.6 Болзошгүй гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд зориулалттай эрсдэлийн сан байгуулж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.


3.7 Нутгийн удирдлагын ордон барина

### **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

4.1 Түүх, соёлын дурсгалт газар, ус, ой, эко систем, ховор амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой эко системийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, тухайн бүс нутагт ажиллаж амьдарч буй иргэд, бүлэг нөхөрлөлтэй хамтран хамгаалалтын оновчтой бодлого хэрэгжүүлнэ.

4.2 Гол, горхи, булаг, шандын эх, гүний худгуудын хамгаалалтын бүсэд болон цөлжилт, элсний нүүдэлд автаж хөрсний элэгдэлд орсон газруудад гүнээс чийг татаж амьдрах чадвартай заг, сухай, хайлаас зэрэг мод болон харгана, улиас, тарьж ногоон хэрэм бий болгоно.

4.3 Ашиглагдаагүй байгаа бэлчээр нутагт худаг гаргах, булаг шанд, цас борооны ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах хэлбэрээр усны нэмэлт эх үүсвэрийг бий болгож, ашиглагдаагүй байгаа бэлчээрийг усжуулсан, ойжуулалт хийсэн малчдын бүлэг, хоршоо, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн санал санаачилгыг дэмжиж, санхүүгийн дэмжлэг олгох, урамшуулах механизмыг бий болгоно.

  
000005



4.4 Сумын оршуулгын газар олголтыг цэгцлэх, орчин үеийн шарил чандарлах технологийг нэвтрүүлнэ.

4.5 Хууль бус алт олборлолтод хяналт тавих, идэвхтэн байгаль хамгаалагчийг унаажуулан ажиллана.

#### **ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ**

5.1 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын гений санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.

5.2 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог хөгжүүлж өргөжүүлнэ.

5.3 Иргэдээ орон нутагт үйлдвэрлэсэн төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн талх нарийн боов, жимс жимсгэнээр хангах "Органик хүнс" төсөл хэрэгжүүлж, өрхийн тариалалтыг дэмжиж дотоодын хэрэгцээний тодорхой хувийг хангана.

5.4 Нутгийн шилмэл омог, үүлдрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна.

5.5 Услалтын системүүдийн ашиглалтыг сайжруулж, төмс хүнсний ногоо, тэжээлийн болон эмийн ашигт ургамал тариалах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.6 Мах, сүүний чиглэлийн мал үржүүлэх бүс нутгуудын малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрч, "Эрүүл бүс" нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг хангаж зах зээлд зарлана.

5.7 Баяд үйлдвэрийн хуцан хурга, Бөмбөгөр сумын Улаан ухна, Хөвсгөл аймгаас эрчмийн хар ухна гэсэн эцэг малыг малчдад нийлүүлэх тал дээр дэмжиж ажиллана.